

Төсөл.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын оны сарын
-ны өдрийн / дугаар хамтарсан
тушаалын дөрөвдүгээр хавсралт

АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД БА ИРГЭНД БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, асаргаанд байх хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэхэд энэхүү зааврыг баримтална.

1.2. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн Эмнэлэг хяналтын комисс (цаашид “ЭХК” гэх), Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (цаашид “ХБХЭМБНХСК” гэх), Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эмнэлэг хяналтын комисс (цаашид “СЭМҮТ-ийн ЭХК”, хамтад нь “Комисс” гэх), эмнэлгийн эмч, сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, мэргэжилтнүүд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох үйл ажиллагаанд энэхүү зааврыг ашиглана.

1.3. Заавар нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, асаргаанд байх хугацааг сунгах, цуцлах, эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээхтэй холбоотой харилцааг оролцогчид нэг мөр мөрдөж хэрэглэх, нийгмийн халамжийн үйлчилгээг ил тод нээлттэй хүргэхэд чиглэгдэнэ.

1.4. Өвчин, эмгэг нь архагшин оюун ухаан, бие махбодын тогтоц, үйл ажиллагаа нь хүндээр гэмтсэний улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, хэвтрийн дэглэмд, бусдын асаргаа сувилгаанд байдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт”, “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт” (цаашид “өвчин, гэмтлийн жагсаалт” гэх) ба “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг үнэлэх шалгуур, үзүүлэлт” (цаашид “шалгуур, үзүүлэлт” гэх)-ийг үндэслэн асаргааг тогтооно.

Хоёр. Комиссын үйл ажиллагаа

2.1. ЭХК, СЭМҮТ-ийн ЭХК, сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч “Эмнэлэг хяналтын комиссын дүрэм”, ХБХЭМБНХСК нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг үйл ажиллагаандаа тус тус баримтлан ажиллана.

2.2. ЭХК-ын хурал нь дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн 3 эмч, ХБХЭМБНХСК-ын хуралдаан нь дарга болон 6 гишүүн, СЭМҮТ-ийн ЭХК-ын хурал нь 4 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдах бөгөөд гишүүдийн 80-аас доошгүй хувийн саналаар байнгын асаргааг тогтоох эсэх, байнгын асаргааны хугацаа сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

2.3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, асаргаанд байх хугацааг сунгах, цуцлахад шаардлагатай бол Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлүүдийн эмч, мэргэжилтнүүд, ХБХЭМБНХ-ын комиссын дэргэдэх мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх Зөвлөлийн гишүүдээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч болно.

2.4. Сумын эрүүл мэндийн төв, ЭХК, СЭМҮТ-ийн ЭХК, ХБХЭМБНХСК нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, явуулын узель, микрофон, электрон урсдаг дэлгэц, зурагт, цахим зарын самбар ашиглах зэргээр шуурхай чирэгдэлгүй үйлчлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Гурав. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох

3.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчлэгч эмч нь бие махбодийн бүтэц, үйл ажиллагаа алдагдсан байдлыг нягтлан магадлах зорилгоор иргэнийг аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сэтгэцийн болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээнд илгээнэ.

3.2. Өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийн дагуу өрх, төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд өвчтөний биеийн байдал, үзлэг, оношилгоо, шинжилгээгээр баталгаажсан онош, өвчний явц, үе шат, хүндрэл, зэргийг тодорхойлон байнгын асаргаа тогтоох үндэслэлтэй бол Комиссын хурлаар хэлэлцүүлнэ.

3.3. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч нь өвчтөний биеийн байдал, үзлэг, оношилгоо, шинжилгээгээр баталгаажсан онош, өвчний явц, үе

шат, хүндрэл зэргийг тодорхойлон байнгын асаргаа тогтоох асуудлыг шийдвэрлэнэ.

3.4. Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хүүхдийн асуудлыг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн мэргэжлийн эмчийн, эсвэл Төрөлжсөн мэргэжлийн баг /“Заавар, маягт батлах тухай” ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаалаар Нэгдсэн эмнэлэг, лавлагаа төвүүдэд байгуулагдсан/ -ийн дүгнэлт, мөн бусад эмнэлгийн байгууллагын мэргэшсэн эмчийн үзлэг, оношилгооны дүгнэлт, хэрэв хүүхэд, түүний асран хамгаалагч Улаанбаатар хотод ирж лавлагаа шатлалын төрөлжсөн эмнэлгийн дүгнэлт авах боломжгүй тохиолдолд тухайн орон нутгийн хүүхдийн зөвлөх эмчийн дүгнэлт, эсвэл цахимаар авсан Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмчийн дүгнэлтийг үндэслэн аймаг, дүүргийн ХБХЭМБНХСК хэлэлцэнэ.

3.5. Эрхтэн системийн гүнзгий дутагдалтай, тээвэрлэх боломжгүй хүүхэд ба иргэний өвчний онош, үе шатыг бүрэн нотолсон эмчлэгч эмчийн үзлэг дүгнэлт, өөрийнх нь хүсэлт зэргийг үндэслэн комиссын гишүүд гэрийн үзлэг хийж, эсхүл комиссын хуралдааны өмнөх 7 хоногийн дотор хийгдсэн тухайн хүний видео бичлэг, зураг зэргийг үндэслэн асаргаа тогтоох асуудлыг хурлаар хэлэлцэнэ.

3.6. ЭХК, СЭМҮТ-ийн ЭХК, ХБХЭМБНХСК нь өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийн дагуу өвчний онош, үе шат, хүндрэл, үзлэг шинжилгээ, оношилгооны дүгнэлтийг үндэслэн байнгын асаргаа тогтоох эсэх талаар хэлэлцэн эцсийн шийдвэрийг гаргана. Шаардлагатай гэж үзвэл холбогдох үзлэг шинжилгээг давтан хийлгэсний дараа тухайн хүнд байнгын асаргааг тогтоох эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

3.7. Байнгын асаргаа шаардлагатай эсэхийг анх удаа тогтоолгож байгаа хүүхэд ба иргэний тухайд өвчний оношийг төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмчээр баталгаажуулсан байна.

3.8. Гадаад улсад удаан хугацаагаар эмчлүүлж байгаа байнгын асаргаа шаардлагатай хүүхэд ба иргэний асаргааны хугацааг шийдвэрлэхдээ үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан, эмчлүүлж байгаа талаарх тухайн улсын эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, биеийн эрүүл мэндийн байдлын талаарх дүгнэлтийн эх хувь, иргэн, асран хамгаалагчийн хувийн хүсэлт зэргийг үндэслэн тухайн комисс шийдвэрлэнэ.

Дөрөв. Байнгын асаргаа шаардлагатай хугацаа тогтоох ба сунгах

4.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатайг тодорхойлсон тохиолдолд өвчин, гэмтлийн жагсаалтад заасан хугацааг баримтлан 6-36 сарын хугацаагаар тогтоох буюу сунгана.

4.2. “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт” дахь мэс заслын өвчнүүдийн үед хагалгаа хийлгэснээс хойшхи заасан хугацааг баримтлан байнгын асаргааг тогтооно.

4.3. Өвчин, гэмтлийн жагсаалтад заасан зарим өвчний үед асаргаанд байх шаардлагатай хугацааны “... сар хүртэл” гэснийг зөвхөн нэг удаа тухайн хугацаагаар тогтоох бөгөөд “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”-ын өвчний заалт, шалгуур үзүүлэлтийн хэсэгт “сунгаж болно” гэж заагаагүй бол дахин сунгахгүй.

4.4. Өвчин, гэмтлийн жагсаалтад заасан асаргаанд байх шаардлагатай хугацааны “...сар” гэснийг заасан хугацааны хүрээнд Комисс хэлэлцэн тогтоож, тухайн хугацааг дуусмагц өвчний явц, хүндрэлийг харгалзан үргэлжлүүлэн заасан хугацааны хүрээнд сунгах эсэхийг мөн хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.5. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэний байнгын асаргааны хугацаа сунгах асуудлыг өмнөх шийдвэрийн хугацаа дуусахаас өмнө, эсхүл уг хугацаа дууссан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Байнгын асаргааны хугацаа сунгахаар шийдвэрлэсэн бол хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд Комиссын хурлаар орсон өдрөөс тооцно.

4.6. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ зааврын 4.5-д заасан хугацаанаас хойш 6 сарын дотор байнгын асаргааны хугацаа сунгуулах хүсэлт гаргасан бол хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох баримтад үндэслэн Комиссын хуралдаанаар орсон өдрөөс эхлэн тооцож, 3 сараас илүүгүй хугацаагаар нөхөн сунгаж болно.

4.7. Оюуны хомсдол болон сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнд байнгын асаргаа шаардлагатай хугацааг 36 сараар тогтоож, мөн хугацаагаар сунгана. 0-16 хүртэлх насны хүүхдийн байнгын асаргааны хугацааг өвчин, гэмтлийн жагсаалтад заасан хугацааны хүрээнд ХБХЭМБНХСК хэлэлцэн тогтооно.

4.8. Комиссын хуралдаанд өөрийн биеэр ирэх боломжгүй буюу эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдаж, эргэшгүй өөрчлөлтөд орсон, хүнд өвчтэй хүний байнгын асаргаа шаардлагатай хугацааг 36 сараар тогтоох бөгөөд хугацаа сунгахдаа холбогдох баримт бичиг, мэдээлэл, зураг, Комиссын хуралдааны өмнөх

7 хоногийн дотор хийгдсэн тухайн хүний видео бичлэг зэрэгт үндэслэн хэлэлцэн шийдвэрлэж болно.

4.9. Байнгын асаргаатай хүн эмчийн зөвлөсөн эмчилгээ, зөвлөгөөг хэрэгжүүлээгүй, хяналтын үзлэгт хамрагдаагүй тохиолдолд байнгын асаргааг цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.

4.10. Байнгын асаргаа шаардлагатай хугацаа сунгахад эрүүл мэндийн байгууллагын цахим мэдээллийн сангаас тухайн хүний эмнэлгийн тусламж, үйлчилгээг авдаг эсэх талаар мэдээлэл авч, шийдвэр гаргахад харгалзана.

Тав. Бусад зүйл

5.1. Комисс нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, хугацаа сунгах, цуцлах тухай гаргасан шийдвэрийг бүртгэлийн журналд тухай бүр үнэн зөв бүртгэнэ.

5.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатайг тодорхойлсон болон хугацаа сунгасан тухай шийдвэрийг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан маягт дээр холбогдох эмч, мэргэжилтнүүд гарын үсэг зурж, тэмдэг тавин баталгаажуулна.

5.3. Комиссын гишүүд харилцан бие биеэ хүндэтгэж, үндэслэлтэй зөв шийдвэр гаргахыг эрхэмлэнэ.

5.4. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтоох, хугацаа сунгах, цуцлах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журмыг зөрчсөн, тухайн хүний нөхцөл байдалтай нийцэхгүй буруу шийдвэр гаргасан, хуурамч бичиг, баримт үйлдсэн эмч, эмнэлгийн байгууллагыг тухайн аймаг, нийслэл, дүүргийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороонд хүргүүлэн дүгнэлт гаргуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.